



## ӨМНӨГОВЬ АЙМАГ

Өмнөговь аймгийн  
2019 оны 9 ДҮГЭЭР сарын мэдээ

### Нэг. Удирлага, зохион байгуулалтын хүрээнд

#### - *Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл*

Монгол улс-БНХАУ хамтын ажиллагааны 70 жилийн ой, Өмнөговь аймаг-БНХАУ-ын Баяннуур хотын хамтын ажиллагааны 30 жилийн ой энэ сарын 25-ны өдөр тохиож байгаа ба уулзалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурал зөвлөгөөний заал танхимыг 9 сарын 10-ны өдрийн байдлаар 82 арга хэмжээний хүрээнд 3219 иргэн, албан хаагч ашиглан сургалт, уулзалт зөвлөгөөн зохион байгуулсан байна.

### Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

#### - *Эрүүл мэндийн чиглэлээр*

Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийн дэмжих нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд эрүүл мэндийн боловсролын жишиг кабинетийг тохижуулан ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн хичээлийн сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдсан. Бэлгийн цогц боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ЕБ-ийн сургуулийн эрүүл мэндийн багш, сургуулийн удирдлагуудыг чадавхижуулах сургалтыг Хүн амын сан, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамтай орон нутагт зохион байгуулж 50 гаруй багш, удирдлагууд хамрагдсан. Дээрх арга хэмжээг зохион байгуулсанаар орон нутгийн эрүүл мэндийн хичээлийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, бэлгийн цогц боловсрол олгох, аюулгүй сургууль хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байсан.

#### - *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр*

Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын 8 багийн дунд “хөгжсөн өрх” уралдааныг зохион байгуулж байна. Энэхүү уралдааны хүрээнд багууд тугайлсан төлөвлөгөө гарган, заавал хөгжих өрхийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд зорилтот өрхийн 70 хүүхдэд /35 цэцэрлэг, 35 сургууль/ хичээлийн иж бүрэн хэрэгслийг гардуулан өгч, сургууль, цэцэрлэгт суралцах боломжийг олголоо. Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байрыг барьж байгуулан, 2019 оны 09 сараас үйл ажиллагааг нь эхлүүлж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хүлээн авч эхлээд байна. Нэг цэгийн үйлчилгээнд ажиллах сэтгэл зүйч, нийгмийн ажлтан, зохион байгуулагчдыг хөтөлбөрийн хүрээнд ажиллах нөхцөл боломжийг нь бүрдүүлсэн. МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор, Хурд хамтлагийн санаачлагаар улс орон даяар зохион байгуулагдаж байгаа “Хайртай” аян 2019 оны 09 сарын 13-15-ны өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулагдлаа. Тус аяны хүрээд эцэг эх, цэргийн албан хаагч, хөвгүүдэд зориулсан сургалтуудад 300 гаруй хүнийг хамруулж, Эх орон дууны клип, МУ-ын Гавъяат Батжаргал гуайн “Битүү амьсгаа” лимэний бичлэгүүдийг хийхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.

#### - *Боловсролын чиглэлээр*

2019 оны 09 сарын 01-ний өдөр 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 22 сургуульд 13451, 29 цэцэрлэгт 5707 хүүхэд элсэн суралцаж байна. 2019-2020 оны хичээлийн жилийн багш нарын бага хурлын арга хэмжээг зохион байгуулж, 350 багш, удирдах ажилтныг хамрууллаа. Тус хурлаар өнгөрсөн хичээлийн жилийн тайлан, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг тавьж, шинэ хичээлийн жилийн зорилго, зорилтоо хэлэлцэж баталсан.

Боловсролын үнэлгээний төвөөс 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг улсын хэмжээнд зарласан. Манай аймаг улсдаа 1 дүгээр байранд орсон амжилтыг үзүүлээд байна. Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн бага сургуулийн барилгын засварын гүйцэтгэгчээр “Логмон” ХХК шалгарч, 60.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгууллаа.

### **Тав. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр Зургаа. Төсөв, санхүүгийн чиглэлээр**

Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 8-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа. Нийт 43 төсөвт байгууллагуудын 2019 оны 8 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан. Төсвийн орлогын 8-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа. Орон нутгийн байгууллагуудын 8 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 9-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 9-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын баталгаажсан ажлын санхүүжилтийг олгож байна. Аймгийн төрийн сангийн харъяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн. Нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг сум, байгууллагуудаас аван нээж ажиллалаа. Төсөв санхүүгийн 8 дугаар сарын мэдээллийг нэгтгэн хэвлэж, Е-оффисст мэдээлэл орууллаа. Хүсэлт ирүүлсэн Булган сумын ЕБСургууль, Цогт-Овоо сумын ЕБСургууль Цогтэций сумын 2-р сургууль, 27-р цэцэрлэг, Даланзадгад сумын ЗДТГазар, төсвийн хуваарийг Fiscal программаар өөрчлөлт оруулан сангийн яамны холбогдох мэргэжилтэнд илгээв. Үндэсний аудитын газрын орлогч дарга С.Бүрэнбатаар ахлуулсан багт төсвийн орлого зарлагын төлөвлөлтийн бодит байдалд хийсэн судалгаанд шаардлагатай судалгаа, мэдээлэл гаргаж өгч ажиллав. Орон нутгийн 2020 оны төсвийн саналд тооцоо судалгааг хийж байна. 2017-2019 оны батлагдсан төсөв гүйцэтгэлээр тооцоо судалгаа гарган ажиллаж байна.

### **Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр**

Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Архангай аймгийн нийт 37 хүнийг 9 сарын 9-11-ний хооронд тусгай төлөвлөгөөний дагуу хүлээн авч үйлчлэв. Үүнээс ХШҮ-ний чиглэлээр 12 хүн ирж туршлага солилцов. Засгийн газрын шийдвэр 11, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 14, аймгийн Засаг даргын 114 захирамж, 2 албан даалгавар, бүгд 141 шийдвэрийг хүлээн авч бүртгэн аймгийн удирдлага, нэгжийн дарга нарт танилцуулах, хяналтад авах, хариуцсан албан тушаалтанд хүргэх ажлыг гүйцэтгэв. Нийт 22 агентлагаас 12 агентлагийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Үлдсэн 10 байгууллагад дараагийн 7 хоногт ажиллахаар төлөвлөж байна. Гадаадын зочид, төлөөлөгчдийг хүлээн авах, баярын арга хэмжээ зохион байгуулахад тодорхой ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Аймгийн ИТХ-ын шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, мэдээг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 9 сарын 24-ний өдрийн хурлаар танилцуулахаар бэлтгэж байна.

### **Найм. Батлан хамгаалах чиглэлээр**

Дорнод аймагт зохион байгуулагдсан Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээнд нийгмийн салбар бүрийн төлөөлөл болох Хүнс хөдөө аж ахуйн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, сум тус бүрийн төлөөлөл, бэлтгэл чөлөөнд суугаа ахмад ажилтан бэлтгэл офицер, ахмадын байгууллага, боловсрол, Зэвсэгт хүчин, хил, цагдаа, онцгой байдлын байгууллагуудаас нийт 30 алба хаагчийг оролцуулан, “Дайчин замналын жимээр” тойрон аялалыг зохион байгуулав. “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны Өмнөговь аймаг дахь салбар холбоог байгуулах анхдугаар чуулганыг зохион байгуулж салбар хорооны тэргүүнээр аймгийн Засаг Н.Наранбаатарыг сонгож, мөн тэргүүлэгчдийг сонгож, салбар холбооны туг, батламжийг хүлээн авсан. Монгол хурандаа нарын холбоотой хамтран ахлах ангийн сурагч нартай “Эх оронч үзэл” сэдэвт лекцийг зохион байгуулав. Халх голын түүхт 80 жилийн ойн нэрэмжит “Тусгаар тогтнол, түүхэн уламжлал, хөгжил дэвшил” бүтээлч аяны хүрээнд 55 байгууллага, давхардсан тоогоор 20,044 хүнийг хамруулан ажил арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд баярын хаалтын арга хэмжээг Батмөнх даян хааны талбайд зохион байгуулж, тэргүүлсэн 6 байгууллагыг өргөмжлөл, мөнгөн шагналаар, тэргүүлсэн болон идэвхтэй оролцсон байгууллагын 27 алба хаагчдыг ойн арга хэмжээнд оролцуулах батламжаар, бусад байгууллагын 46 алба хаагчийг аймгийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар, 80 хүнийг өргөмжлөлөөр, 12 алба хаагчийг батлан хамгаалах салбарын медиалаар, 30 иргэнийг Халх голын 80 жилийн ойн медалиар шагнуулах ажлыг зохион байгууллаа.

## **СУМДЫН МЭДЭЭ**

### **БАЯНДАЛАЙ СУМ**

#### **Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр**

Засаг даргын А захирамж 8, Б захирамж 1, нийт 9 захирамж гаргасан. А захирамж: -Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай, цол олгох, ээлжийн амралт, говийн дэмжлэг, газар эзэмших эрхийн дуудлага худалдаа, урамшуулал олгох тухай. Б захирамж: Ажилд томилох. ЗДТГазрын даргын А тушаал 2, нийт 2 тушаал гаргасан А тушаал: -Комисс томилох, Засаг даргын тоот-5, Өргөдөл гомдол-2 Ажилд орох, Хашаажуулах тухай, Ирсэн бичиг-17, хугацаандаа яваа-1, шийдвэрлэж хаасан-2. Шуурхай хурал-3 удаа тус тус хийсэн байна.

#### **Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт**

Төрийн албан хаагчдын хувцаслалтын тухай нэг удаагийн сургалтыг нийт төрийн албан хаагчдад хийсэн.

#### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ**

Сургууль, цэцэрлэгүүд амарсан тул мэдээлэл байхгүй. 07 дугаар сарын 01-нд Дэлхийн аварга Ц.Раднаа багшийн нэрэмжит сумын баяр наадмыг зохион байгуулсан. Говийн Оюутан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутан залуучууд сумын цэцэрлэгт хүрээлэнд ээжүүд болон болон хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх орчинг бий болгож өгсөн. Мөн гүний усны худаг, айлын хашааг будаж өнгө үзэмжийг сайжруулан ажилласан.

#### **Тав. Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”**

Наран багийн 60 жилийн ойн ажлын хүрээнд Наранбагт зүлэг, мод тарих, бүтээн байгууллатын ажлыг хийж жишиг баг болох ажлуудыг хийж байна. Өмнөговь аймаг 2018 оны ажлаараа улсдаа тэргүүлж хошой тэргүүний аймаг болсонтой холбогдуулан төрийн үйлчилгээний 29 албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Спорт заалны барилгын ажил суурийн цутгалт 50 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн ажил хийгдэж ажил, Соёлын төвийн барилгын ажлууд эхэлсэнтэй холбогдуулан түр ажлын байр бий болж одоогийн байдлаар сумын харьяат 12 хүн ажиллаж байна.

## **БУЛГАН СУМ**

#### **Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр**

Засаг дарга нь 09 дүгээр сарын байдлаар Төсвийн сар улирлын хуваарь батлах тухай 1, Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай 2, газрын хэмжээ өөрчлөх тухай 1, Хөрөнгө зарцуулах тухай 2 нийт

6 захирамж гаргасан. Тамгын газрын дарга нь 09 дүгээр сарын байдлаар Үнэлгээний хороо байгуулах тухай 3 тушаал гаргасан. 2019.09.02-нд багш, ажилчдын цуглаан хийж захирал ажилчдад хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангахад бүтээлч, идэвх санаачлагатай оролцсонд, мөн багш нарыг палентологийн сургалтанд бүгд идэвхтэй хамрагдаж оролцсонд тус сургуулийн захиргааны зүгээс баяр хүргэж талархал илэрхийллээ.

#### **Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт .**

Халдвар хяналтын сургалтанд эмнэлэгийн эрхлэгч, лаборант нар хамрагдсан. 2019.09.16-09.20-ны хугацаанд сургалтын менежер аймагт БСУГазрын арга зүйч Оюунчимэгтэй хамтран төвийн зарим сургуулийн бага ангийн хичээлд хамтран сургалт, хичээлд сууж байна. 2019.09.20-09.22-ний хугацаанд тус сургуулийн багш нар, ажилчид аймагт явагдах багш нарын баяр угтсан нэгдсэн арга хэмжээ уралдаан тэмцээнд оролцлоо.

#### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ**

2019.09.16-нд багш, ажилчдын цуглаан хийж 2019-2020 оны хичээлийн жилийн сургуулийн зорилго, зорилтоо тодорхойлж харилцан санал бодлоо солилцож хэлэлцэж гаргалаа. Сургууль нь “Дрийн говь” жуулчны баазтай хамтын ажиллагаатай байдаг бөгөөд сургуулийн хүүхдийн “Говийн домог” хамтлагийг тоглолтыг ивээн тэтгэж дэмжиж ажилладаг компанийн жуулчид сургуулиар ирж хүүхдүүдийн тоглолт, англи хэлний онлайн танхимын үйл ажиллагаатай танилцаад явлаа. Төсөвт байгууллагуудын 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг нэгтгэн Төрийн сангийн программд шивж мэдээлэв.8-р сарын Орон нутгийн орлогыг хаалтын дансруу хааж, гүйцэтгэлийг татварын байцаагчтай тулган аймагт мэдээлэв.Аймгаас ирсэн 2019 оны 9-р сарын санхүүгийн дэмжлэгийг орлогын дансанд хааж, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг олгов. 2019 оны 8-р сарын шилэн дансны мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулж, байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллав.

#### **Дөрөв. Тухайн сард кохион байгуулсан ажил**

Сургууль, цэцэрлэг нь 2019.09.02-нд 2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлтээ хийлээ.2019.09.09-нд багш нарын баярыг тохиолдуулан ажилдаа амжилт бүтээл гаргасан зарим багш, ажилчдыг БСШУСЯам, БСУГазрын шагналд тодорхойлов. Жил бүр уламжлал болон явагддаг “Алтан намар” ногооны баяраа энэ жил ахмад багш, агсан О.Рэнцэнмядагийн нэрэмжит “Эко фестиваль-2019” уриан дор амжилттай зохион байгуулагдлаа. Сумын ард иргэдийн алтан намар арга хэмжээ нь “Нутгийн намар-2019” нэр доор цагаан идээ, ногооны хамтарсан урлаг, спортын арга хэмжээтэй боллоо.Мөн ахмадын баярын хүндэтгэлийн арга хэмжээ 09.30 нд зохион байгуулагдахаар төлөвлөн ажиллаж байна. Төрийн албаны нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдлаа.Багуудын ээлжит хурал боллоо.

### **МАНДАЛ-ОВОО СУМ**

#### **Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.**

Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол гараагүй. Сумын Засаг даргын захирамж 6, ОНХС-н хөрөнгөөр хэрэгжсэн ажил хүлээн авах комисс байгуулах тухай, Гэрээ байгуулж санхүүжилт олгох тухай-3, Нөөц сангаас хөрөнгө зарцуулах тухай, Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, бүлэг, хэсэг, сайн дурын бүлгийг шинэчлэн байгуулах тухай/. Тамгын газрын даргын тушаал 3 гарсан байна. /Хөрөнгө зарцуулах тухай, Жирэмсэн амаржсаны амралт олгох тухай, Хөдөлмөрийн гэрээ байгуулж түр ажилд авах тухай/ Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 3 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар мэдээлэл солилцож, ярилцаж шийдвэрлэв.

#### **Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт**

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 3, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 1 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэв.

Үүнд:

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 2 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар мэдээлэл солилцож, ярилцаж шийдвэрлэсэн байна.

Үүнд:

- Өргөдөл хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэх тухай
- Нутгийн удирдлагын ордны гэрээ байгуулах тухай
- Түүхий эд боловсруулах цэгийн гэрээ байгуулах эрх олгох тухай
- Эсгийний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулах тухай
- Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээлэл түгээх тухай
- ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх Гэрэлтүүлэг шинээр хийх, гэрэлтүүлгийн засварын ажлын гэрээ байгуулах тухай
- Бог малын хээлтүүлэгчийг ялган суурилуулах суурийн хашаа, худаг засварлах ажлын гэрээ байгуулах тухай
- Тамгын дарга Баянхонгор аймагт Цэргийн сургалтад хамрагдах тухай
- Цэвэр бохир усны шугамын ажилд хяналт хийх тухай
- Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй төслийн гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай
- Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх Ясли-хүүхдийн хөгжил төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах тухай
- Мандал Баянхошуу багийн өвөлжөө хаваржааны цэгийг тогтоох тухай

#### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

Сургууль, цэцэрлэгийн нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулав. Нутгийн удирдлагын ордны барилгын ажилд сумын ХШҮ-ний 3 гишүүн хяналт хийв. Түүхий эд боловсруулах тоног төхөөрөмж болох чийглэг болон хуурай нэхий элдэгч, пресслэгч машинуудыг Батжин-Ойл ХХК-с ажлын хэсэг хүлээн авав. ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх Гэрэлтүүлэг шинээр хийх, гэрэлтүүлгийн засварын ажлыг хүлээн авав. Говийн оюу ХДС-н квотийн хөрөнгөөр санхүүжигдэх 4 ажлын санхүүжилтийн гэрээ байгуулах хүсэлтийг Говийн оюу санд хүргүүлж гэрээг байгуулав. Баянхошуу багийн хурлаар Нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулж 32 иргэнд Нийгмийн даатгал, газар, ХАА, Нотариатын үйлчилгээг үзүүлж мэдээлэл хийв. Эмнэлгийн барилгын нээлтийн арга хэмжээ зохион байгуулж, УИХ-н гишүүн, Нутгийн зөвлөлийн дарга Л.Энхболд, аймгийн Засаг даргын орлогч Батболд, Оюу толгой ХХК, Говийн оюу ХДС-н удирдлагууд, иргэд оролцов. Ахмадын баярыг 9 сарын 16-нд өргөн тэмдэглэж 64 ахмад оролцож, урлаг спортын 8 төрлөөр өрсөлдөж сайхан баярлав. Цэргийн холбооны чуулганд 3 иргэн оролцов.

#### **Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд**

Баянхошуу багийн ИНХурал хуралдаж, 38 иргэн оролцож, багийн ЗД-н мэдээлэл сонсож, багийн 60 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах комисс байгуулав. Нэг цэгийн үйлчилгээгээр 32 иргэнд үйлчилгээ үзүүлэв.

бүр 10-12 цагын хооронд ахмадууд спорт заланд тогтмол бэлтгэл хийж хэвшиж байна.

### **ХАНБОГД СУМ**

#### **Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр**

Ирсэн бичиг-25, Хугацаа хэтэрсэн-0, Шийдвэрлэсэн-5, Өргөдөл, гомдол-0, Засаг даргын захирамж- А-1, Б-0, Засаг даргын тоот-5, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал- А-0, Б-0, Засаг даргын Тамгын газрын даргын Шуурхай хурал-1, ИТХ-ын тогтоол -0 тус гаргасан байна.

#### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ**

Сургууль цэцэрлэгийн нээлтийг хийж үйл ажиллагааны жигдрэлтийг хангуулсан. Сумын хэмжээнд сургууль цэцэрлэгийн бүртгэлийг хийж анги хуваарилалтанд хяналт тавин ажиллав. Сумын хэмжээнд ЗООНОЗ өвчин судлалын сургалтыг зохион байгуулж иргэдийг хамруулж ажиллаа. Аймгийн засаг даргын захирамжийн дагуу ХААГ-аас зохион байгуулсан мал угаалга хороо бууц ариутгалыг хийж ажлын явц 80 хувьтай хийгдэж байна. Ханбогд сумын Хайрхан багийн газар олгох дахин

төлөвлөлтийн ажлыг зохион байгуулж ажлын хэсэг байгуулан ИНХ-ийг хийж, Хайрхан багийн орчмын хог хаягдлыг байгаль орчны байцаагч тамгын газрын мэргэжилтэн, багийн иргэдтэй хамтран ажиллаа. НҮБ-ын хүн амын сан, Залуучуудын холбоо, ГБХЗГ-аас зохион байгуулсан залуучуудын чуулга уулзалтанд 10 хүний бүрэлдхүүнтэй оролцов. ӨМӨЗО-ны уртын дунд хошуу Халиут хоттой хамтран ажиллах найрсаг харилцааны хүрээнд тус хотын Эмнэлэг, Урлагийн газрын бүтэн бүрэлдхүүн Ханбогд суманд ирж ард иргэдэд эмнэлэгийн үйлчилгээ болон урлагийн тоглолт үзүүлж Үлэмжийн чанар соёлын төвийн Климанжоро номын санд ном хандивлаж Уран бичлэгийн багш авьяастан сургалт явуулж хүүхэд багачууд ард иргэдэд үйлчиллээ. Сум дундын эмнэлэгт компьютерийн дэмжлэг үзүүллээ. Сум дундын эмнэлгийн эмч нар компьютер дутагдалтай байгаагийн улмаас дотоод сүлжээнд бүх эмч холбогдож чадаагүй, өвчтөний мэдээллийг гараар бичиж авдаг зэрэг хүндрэлүүд гарч байсан. Хойшид өвчтөний мэдээллийг нэг бүрчлэн систем дээр хадгалах, урьдчилан сэргийлэх үзлэг хийгдэхэд бүх эмч компьютертой байх, дотоод сүлжээнд холбогдох зайлшгүй шаардлага тулгарч байсан. Энэхүү асуудлаа “Оюу Толгой” ХХК-ийн “Орон нутгийн харилцааны хэлтэс”-т хүргүүлсэн. Тэд бидэнд дутагдалтай байгаа хэрэгцээг ойлгож дотооддоо “Мэдээлэл технологийн хэлтэс”-т манай хүсэлтийг уламжилж шийдүүлж өглөө. Дутагдалтай байгаа 13 суурин компьютер, 2 нөтбүүк-ийг 9-р сарын 28-ний өдөр “Орон нутгийн харилцааны хэлтэс”-ийн менежер С. Дорждэрэм, “Мэдээлэл технологийн хэлтэс”-ийн менежер Г.Чинзориг нар хүлээлгэн өглөө. Америкийн нэгдсэн улсын Монголд суух элчин сайд М.Клечески Оюу толгой ХХК болон Ханбогд суманд зочилон ирж сумын байдалтай танилцан хамтран ажиллах боломж бий гэдгийг цохон цаашид хамааралтай ажил үйлст туслаж дэмжин хамтрахаа илэрхийллээ. Үерийн далангийн ажил амжилттай хийгдэж байна. 11-р сард ашиглалтанд орно. Хөрөнгө оруулагч ОТ.ГОХДСан. тус ажилтай танилцлаа. Дотоодын хурлыг 1 удаа хийсэн.

#### ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР